

Үндэсний статистикийн газрын  
даргын 2007 оны 4 дүгээр сарын 02-ны  
өдрийн 01/43 дугаар тушаалын II  
хавсралт

**Сум, баг, хорооны статистикийн шилдэг ажилтан  
шалгаруулах журам**

**Нэг. Зорилго**

1.1 “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу улсын хэмжээнд аймаг, нийслэл, дүүрэг, сум, баг, хороодод статистикийн анхан шатны нэгжийн мэдээллийн үнэн бодит байдлыг дээшлүүлэх, хамралт шуурхай байдлын болон бүртгэл мэдээллийн боловсруулалтыг сайжруулах, Албан ёсны статистикийг 2006-2010 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг идэвхижүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2 Сумын статистикийн мэдээ хариуцсан ажилтан, баг, хорооны Засаг дарга нараас анхан шатны бүртгэл мэдээллийг сайжруулахад оруулсан хувь нэмэр, ажлын үр дүнг үнэлж дүгнэж урамшуулах, тэргүүний туршлагыг нийтэд түгээн дэлгэрүүлэхэд энэхүү журмыг баримтална.

**Хоёр. Сум, баг, хорооны статистикийн шилдэг ажилтан  
шалгаруулах болзол**

2.1 Сум, баг, хорооны статистикийн шилдэг ажилтнаар шалгарсан ажилтнууд дараах болзлыг хангасан байна.

Үүнд:

- 2.1.1. Сумын статистик мэдээлэл хариуцсан ажилтан, баг, хорооны засаг дарга нар нь уг албанд 3-аас доошгүй жил ажилласан байх;
- 2.1.2. Статистикийн мэдээллийн хамралт, мэдээний үнэн бодит байдлыг хангаж, мэдээ тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж, хэвшсэн байх;
- 2.1.3. Анхан шатны бүртгэл, мэдээллийн хамралт, шуурхай, үнэн бодит байдлыг хангаж, тодорхой шинэ ажлыг санаачлан хийж, бодитой үр дүнд хүрсэн байх;
- 2.1.4. Статистикийн албаны үйл ажиллагаа, статистикийн мэдээллийн ач холбогдлыг сурталчлах талаар тодорхой ажлуудыг хийж хэвшсэн байх;

2.2 “Сумын статистикийн шилдэг ажилтан”-аар шалгаруулах үзүүлэлт

	Дүгнэх үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээний оноо			
			1	2	3	4
1	Албан ёсны статистикийн мэдээ, тайланг баталсан маягт, аргачлал, зааврын дагуу графикт	Суманд үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэдийг албан ёсны статистикийн мэдээнд бүрэн хамруулж байгаа байдал				

	Дүгнэх үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээний оноо			
			1	2	3	4
	хугацаанд дамжуулсан ирцийн дүн	Албан ёсны статистикийн мэдээний ирц				
		Албан ёсны статистикийн мэдээний бодит байдал				
		Маягтын үзүүлэлтүүдийг бүрэн тооцож бөглөсөн, гаргасан алдаа зөрчилгүй байх				
2.	Статистикийн тооллого, түүвэр судалгаанд оролцсон байдал	Албан ёсны статистикийн тооллого, түүвэр судалгаанд оролцсон байдал /тоологчоор ажилласан, зохион байгуулсан гэх мэт/				
		Түүвэр судалгаанд сонгогдсон өрхийг бүрэн хамруулсан байдал				
3	Статистикийн тухай хуулийн хэрэгжилт, мэдээний бодит үнэн зөвийг хэрхэн хангасан байдал	Сар, улирал бүр сумын эдийн засаг-нийгмийн байдлын тухай танилцуулга гаргаж сумын удирдлага болон иргэдэд үйлчилсэн байдал				
		Статистикийн үйл ажиллагааг багт зохион байгуулж, мэдээлэгчдэд мэргэжлийн зөвлөгөө, чиглэл өгч, аргачлал гарын авлага, бусад материал, мэдээллээр хангаж мэдээллийн ач холбогдол, чанарыг сумын удирдлага, иргэдэд сурталчлах ба мэдээллээр хангасан байх				
		Сумаас бусад газар, хэлтэс, агентлагт ирүүлсэн салбарын захиргааны мэдээлэл нь аймагт ирүүлсэн албан ёсны статистикийн төвлөрсөн мэдээлэлтэй бүрэн тохирч, давхардалгүй болсон байх				
4	Сумын статистикийн мэдээлэл, тооллого, судалгааны үр дүнгээр мэдээллийн сан байгуулж, бизнес регистрийн санг үүсгэн хөтлөж, мэдээ тайлангийн хамралтын хувь хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байдал, компьютер ашиглалт	Тооллого, тодорхой сэдвээр иж бүрэн буюу түүвэр судалгааг заавар, зөвлөмж, маягтын дагуу зохион байгуулж явуулсан байдал				
		Сумын статистикийн мэдээлэл, тооллого, судалгааны үр дүнгээр мэдээллийн сан байгуулж, сумын эдийн засгийн динамик хөтлөлт				
		Сумын бизнес-регистрийн санг тогтмол хөтөлж, өөрчлөлтийг тусгасан байдал				
		Суманд эдийн засаг-статистикийн мэдээллийг компьютер ашиглаж боловсруулалт хийдэг болсон байх				
5	Сумын өрх хүн	“Хүн ам, өрхийн бүртгэл”-ийн дэвтрийн				

	Дүгнэх үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээний оноо			
			1	2	3	4
	амын бүртгэлийн байдал	хөтлөлтийн байдал				
		“Хүн амын мэдээллийн сан”-гийн бүрдэлт				

### 2.3 “Баг, хорооны статистикийн шилдэг ажилтан”-аар шалгаруулах үзүүлэлтүүд

	Дүгнэх үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээний оноо			
			1	2	3	4
1	Баг, хорооны өрх, хүн амын бүртгэлийн байдал	“Хүн ам, өрхийн бүртгэл”-ийн дэвтрийн хөтлөлтийн байдал				
		“Хүн амын мэдээллийн сан”-гийн бүрдэлт				
		Иргэний бичиг баримтын зөрчлийг илрүүлж, арилгуулсан байдал				
2	Мал тэжээвэр амьтадын тооллого	Тухайн жилийн тооллогыг алдаагүй гаргаж тушаасан байх				
		Мал, тэжээвэр амьтдын бүртгэл, судалгааны байдал				
		Тэжээвэр нохой, муурны бүртгэл хөтлөлт, паспортжуулалтын байдал				
3	Ажил эрхлэлтийн тайлан	Тухайн жилийн тайланг алдаагүй гаргаж тушаасан байх				
4	Албан ёсны статистикийн мэдээ, тайланг баталсан маягт, аргачлал, зааврын дагуу графикт хугацаанд дамжуулсан ирцийн дүн	Баг, хороонд үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн албан ёсны статистикийн төвлөрсөн мэдээнд бүрэн хамруулж, үнэн, зөв, алдаагүй шуурхай байдлыг бүрэн хангаж дамжуулсан байх				
		Баг, хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бүртгэл бүрэн гүйцэд, байнга шинэчилсэн байдал				
		Баг, хорооны гэр, орон сууцны бүртгэлтэй хөтөлж байгаа байдал				
		Баг, хорооны иргэдийн нийгмийн байдлын судалгаа, бүртгэлийг бүрэн шинэчилж байгаа байдал				
5	Баг, хорооны хэмжээнд мэдээллийн сантай болох	Олон жилийн динамик судалгаа хийгдсэн байх, гол үзүүлэлтүүдээр /өрх, хүн ам, нийгмийн судалгаа, малын тоо, төрлөөр, боловсрол судалгаа, амьжиргааны байдал гэх мэт/				

	Дүгнэх үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ оноо			
			1	2	3	4
		Динамик үзүүлэлтүүдээр мэдээллийн сан байгуулж байдал, хэрэглэгчдэд үйлчилж байгаа байдал				

2.4. Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсээс тодорхойлж ирүүлсэн ажилтанд үнэлгээ өгөхдөө шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангасан байдлыг харгалзан хийсэн ажлын хүрээнд 1-3 оноо өгч дүгнэнэ. Хийгдсэн ажлын оноог нийт авах оноонд харьцуулан хувилж гаргана. Нийт авах оноо нь 20 байна.

- Шаардлагаас үлэмж дээгүүр -4 оноо
- Шаардлага бүрэн хангаж байгаа -3 оноо
- Шаардлагын хангаж байгаа -2 оноо
- Шаардлагын хэмжээнд огт хүрээгүй -1 оноо

### **Гурав. Сум, баг, хорооны статистикийн шилдэг ажилтан шалгаруулж, урамшуулах**

3.1. Аймгийн статистикийн хэлтэс нь статистикийн мэдээлэл хариуцсан сум, багийн түвшний тус бүр нэг ажилтан буюу 2 хүнийг, нийслэлийн статистикийн газар нь нэг хорооны Засаг даргыг тодорхойлон ҮСГ-т жил бүрийн 10 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ.

3.2. “Статистикийн шилдэг ажилтан”-ыг тодорхойлохдоо дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- 3.2.1. Нэр дэвшсэн хүний анкет, 4х6 хэмжээний фото зураг 2 хувь
- 3.2.2. Хяналт, шалгалтын ажлын тайлан, түүний мөрөөр зохиосон ажил
- 3.2.3. Нийслэл, аймгийн статистикийн хэлтэс, газрын тодорхойлолт
- 3.2.4. Нэр дэвшсэн хүнийг аймаг, нийслэлийн статистикийн албадаас энэ журмын шалгуур үзүүлэлт, аргачлалаар үнэлсэн үнэлгээний хуудас

3.3. Статистикийн шилдэг ажилтны шалгаруулалтын дүнг ҮСГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.4. Улсын хэмжээнд Статистикийн шилдэг ажилтнаар шалгарсан сумын 3 статистик мэдээлэл хариуцсан ажилтанг шалгаруулж “Өргөмжлөл”, тус бүр хоёр сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар шагнаж, ҮСГ-ын “Сурталчилгааны самбар”-т зургийг тавьж алдаршуулна.

3.5. Улсын хэмжээнд Статистикийн шилдэг ажилтнаар шалгарсан баг, хорооны 3 Засаг даргыг шалгаруулж “Өргөмжлөл”, тус бүр хоёр сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар шагнаж, ҮСГ-ын “Сурталчилгааны самбар”-т зургийг тавьж алдаршуулна.